

ХҮИИ зууны тэргүүн хагасын Монгол, Манжийн
харилцаанд холбогдох баримт бичгүүд
(үргэлжлэл)¹

Доктор/ PhD/ Г.Дашням,
Ц.Төрбат, Магистр Д.Энхцэцэг

Бид энэ товч оршилд, нийтлүүлж буй баримт бичиг тус бүрийн тухай танилцуулах боломжгүй боловч Халх Монгол, Манжийн харилцааны эхэн үед холбогдох 4 баримтыг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Эдгээр баримт нь "Халхын Сэцэн хан Шолой, Түшээт хан Гомбодорж, Үзэмчний Дорж Сэцэн жонон тэргүүтэй Халхын их, бага ноёдоос Манжийн хаанд илгээсэн бичиг" (1635 он)², "Халхын Сэцэн хан Шолойгоос Лигдэн хутагт хааны хатад хөвгүүд, харъяат ноёдод буулгасан зарлиг" (1635 он)³, "Сэцэн хан Шолой тэргүүтэй Халхын ноёдоос Манжийн хаанд илгээсэн бичиг" (1636 он)⁴, "Манжийн хаанаас Халхын Сэцэн хан Шолойд илгээсэн бичиг" (1636 он)⁵ болно.

Эдгээр баримт бичгүүд нь Ар Халхын хан, ноёд, тайж нар манж нартай анх хэзээ хэрхэн харилцаж эхэлсэн, тэд манж нар Өвөр Монголын нутгийг эзлэн, Лигдэн хутагт хаан Шар талд нас нөгчин Монгол улсын их хааны ор суларсан хэрэг явдлыг хэрхэн үнэлж байсан, манж нартай харилцахдаа анх ямар бодлого баримталсан зэрэг асуудлын талаар шинэ мэдээлэл өгч, манай түүх бичлэг дэх зарим ташаарлыг залруулан, шинэ, шинэлэг санал дэвшүүлэх боломж олгож байгаа юм.

Тодруулбал, тэдгээр баримт бичгийн агуулгад түшиглэн дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж болох байна. Үүнд, а) Халхын феодалын дотроос газар нутгийн дөтийн хувиар 1635 онд Сэцэн хан Шолой, дараа нь 1638 онд Түшээт хан Гомбодорж, засагт хан Субадай нар элч зарж манж нартай харилцсан гэдэг ойлголт ташаа болох нь тодорхой болж байна. 35-р баримтаас үзвэл, 1635 оны зун Сэцэн хан Шолой, Түшээт хан Гомбодорж, Сэцэн ханыг түшиж ирсэн Үзэмчний Дорж Сэцэн жонон тэргүүтэй Монголын их, бага олон ноёд нэр хамталж Манжийн хаанд элч зарж харилцжээ. Энэ бол Ар Халхын ноёдоос Манжийн хаанд элчин зарж харилцсан анхны харилцаа байв; б) 1636 онд Өвөр Монголыг Манжийн захиргаанд албан ёсоор оруулж, Манжийн Амбахай хааныг "Богд Сэцэн хаан" хэмээн тунхаглан зарлахаас жил орчмын өмнө Ар Халхын болон Халхыг түшин орж ирсэн өвөрлөгч аймгийн хан, их, бага ноёд хамтран хэлэлцэж, Манж нартай цаашид хэрхэн харилцахаа зөвлөлдөн шийдвэрлэж байжээ; в) 1635 онд Ар Халхын ноёд манж нартай анх харилцахдаа "Лигдэн хутагт хаан биднийг жолоодон захирч чадаагүй боловч хан төрөлт бид Монголын хас төрийг алдалгүй харж сууна. Тиймээс бус хүн Монголын хас төрийг захиран суух учиргүй. Монголын хас их төрийг бид хадгалан суугаа тул Халх Монгол, Умард Алтан улс нь айл хөрш улсын ёсоор элч харилцан зарж, найртай ёсоор харилцах нь зүй. Ийнхүү явах нь бидний "гавъяа" ба үүрэг" гэсэн байр суурийг хатуу баримталж байжээ; г) 1634 онд Лигдэн хутагт хаан нас нөгчсөнөөр Монголын их хааны ор суларч түүний албан ёсны залгамжлагч Эжэй эрх хонгор, Абунай нарыг Манжийн хаан өөртөө татан авч нийт монголчуудыг эзлэн түрэмгийлэх үйлсдээ ашиглаж болзошгүй нөхцөл байдал бий болсныг Ар Халхын Сэцэн хан Шолой тэгүүтэй ноёд бодитойгоор үнэлж, тэднийг манж нараас өрсөн Ар Халхын нутагт ирүүлэх арга хэмжээ аван тусгай элч зарж, зарлиг буулгаж байсан боловч тэрхүү зарлиг бичиг нь Манжийн хааны гарт орж уг хэрэг бүтээгүй ажээ; д) Лигдэн хутагт хааны хатад, хөвгүүд, харъяат ноёд, ардыг нь Ар Халхын нутагт урин авчрах заллагын бичгийг дан ганц Сэцэн хан Шолойн нэрээр үйлдсэн боловч энэ нь Сэцэн хан Шолой, Түшээт хан Гомбодорж нарын Халхын их, бага ноёд ямар нэг хэмжээгээр хамтран хэлэлцэж

¹ Түүрүүч нь МУИС-ийн ЭШБ. №7/158/. УБ., 2000 он. Тал 74-105

² 35-р баримт бичгийг үзмү.

³ 36-р баримт бичгийг үзмү.

⁴ 37-р баримт бичгийг үзмү.

⁵ 38-р баримт бичгийг үзмү.

шийдвэрлэсэн хамтын нэн чухал шийдвэр байсан ажээ; е) Лигдэн хутагт хаанаас хойш нийт монголчуудын тусгаар тогтнолын хувь заяа, манж нартай харилцах харилцаанд хамгийн их нөлөө үзүүлж чадахуйц нэр нөлөөтэй хүн нь Сэцэн хан Шолой болжээ. Үүнд, Сэцэн хан Шолойн угсаа гарал, эрх хүчин чадал, эзэмшил нутгийн байрлал, Өвөр Халх, Ар Халхын харилцаанд гүйцэтгэж ирсэн үүрэг, өвөрлөгч нарын зарим нь түүнийг түшин амьдарч байсан зэрэг нь нөлөөлжээ. Сэцэн хан Шолой ч өөрийн нэр нөлөө, ноогдсон хариуцлагыг зөвөөр ухамсарлаж Халхын ноёдын үзэл бодол, хүчин чадлыг нэгтгэхэд хошуучлан зүтгэж байжээ; ё) 1635 онд Манжийн хаан Амбахай Мүгдэн хотноо Өвөр Монголын 16 аймгийн 49 ноёдыг цуглуулан, Өвөр Монголыг Манжийн захиргаанд оруулж, биеэ бүх Монголын хаанаар өргөмжлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон үед, 1636 оны 1-р сард Халх Монголын Сэцэн хан Шолой тэргүүтэй Халхын ноёд хоёрдахь удаагаа Манжийн хаанд элч заран харилцахдаа өмнөхөөсөө алхам ухарч, Өвөр Монголыг Манж нар эзэлснийг хүлээн зөвшөөрсөн боловч Халхын ноёд Манжийн хааныг Монголын хаан хэмээн хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж, тус тусдаа төр, шашнаа мандуулан, эрх тэгш хөрш улсын ёсоор харилцан найртайгаар харилцан явъя гэдэг байр суурин дээрээ хатуу зогссон хэвээр байжээ.

Баримт бичгүүд

24. МАНЖИЙН ХААНААС ХОРЧИНЫ ТҮШЭЭТ ХАНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг. Түшээт хаанд бичиг илгээв. Нагуны ялдагч ноёд. Ялгүй ч ноёд. Мэнд асууя гэж ирэхийг хорьж байлга. Агтын хүч эвдрэх. Аливаа ялт торсон ноёд агтын хүчийг эвдэлгүй явжхэлэлцсэн цаазын үгэндээ хүрч явахул хэрэгтэй буй жа. Хэлэлцсэн үгээ эвдээд агтын хүч эвдэн. Аливаа аянд хүрч ирэлгүй явж байж. Мэнд асууя гэж ирэх юун хэрэг.

25. МАНЖИЙН ХААНААС ТАНШАЙД ЦОЛ ОЛГОСОН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг. Далингхугийн байрт Таншайг сайн явав гэж. Хуяг өгч Дархан Хошууч цол өгөв. Үүнээс хамгийн элчид, аливаа ноёд. Улаа үл унах. Шүүс үл идэх. Энэ Дархан цол үрийн үрд хүртэл үл тасрах.

26. МАНЖИЙН ХААНААС МОНГОЛЫН НОЁДОД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Хааны зарлиг. Хошуугаа мэдэх ноёд бүгд аливаа өгөх авах ялтныг аван шинэ сарын зургаан шинэд Дөрвөн хүүхэд дээр цугла энэ цуглаанд эс ирэхүл. Цуглагчин ноёд түүний дээр бууж улаа унаж шүүс идэх. Ноёд үрээ даага уна. Энг⁶ ялтан үхэр тэмээ уна. Агтын хүч бүү эвд. Ил гарсан хэдэн хулгайч болоос⁷ бүгд барьж авч ир. Хулгайчийг далдлаж хэр бэ⁸ оргож босч эчихүл түүний ноёнд нь их ялтай буй.

27. МАНЖИЙН ХААНААС ХАРЧИН МОНГОЛД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Хааны зарлиг . . . ийг⁹ умарталгүй . . .¹⁰ хорин хүнд нэг их дарга, нэг бага дарга тавь. Цоргиражу их дуун бүү гар. Их дуун гарахул. Хошууны эзэн. Отгийн эзэн. Галын эзэн. Хорин хүний дарга эдэнд ялтай. Дуун гарсан хүнийг цаазаар жираху (?). Явахад тугаас хагацаж үгүй. Хошоод явах хүнийг барьж, тэр хошууны эзэнд нь хүргэж гурван лан мөнгө ав. Ус түлээнд илгээхэд таван хүнээс дээш хошуулж илгээ. Гал алдахул алах ял. Хуягаас доош шадараас дээш аливаа юманд бүгд бичиг бич. Моринд тамга дар. Дэл сүүлд бичиг өг. Хазаар ногтыг хулгай хийхүүл. Амийг нь заах. Тохмыг хулгай хийхүүл нурууг хагалах. Чөдрийг хулгай хийхүүл хүзүүг огтлох. Туулай хяруулд довтлохул сайн хүн болоос арван лан мөнгө авах. Муу хүнийг занчих.

⁶ Энгийн (?)

⁷ болбоос

⁸ хэrvээ

⁹ Энд уг эхдээ 7 үг байсан нь гаргагдахгүй болжээ

¹⁰ Энд 3 үг байсан нь гаргагдахгүй болжээ.

28. МАНЖИЙН ХААНААС МОНГОЛЫН ЖАЛАЙД, ГОРЛОС, ЭЛЖИГИЙН ХҮҮХДЭД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Хааны зарлиг бичиг. Жалайд, Горлос, Элжигийн хүүхэд. Нэг морины үнээр танаас дөрөв тав морь авахын тул. Танд худлаар айлгаж өөрт бүү ортугай гэнэм бишүү. Тэдний үгэнд бүү ор. Цахарын хаан Авгын жононд цэрэг мордсон учирт. Бид Цахараас хэл барьж ир гэж илгээж билээ. Тэр илгээснийг мэдэж жононг шамдаж нэхэлгүйгээр зүг яарч харьж гэлээ. Манайх Хятадад мордсоныг Цахар мэдэж Далайг довтлоод. Манай цэрэг буцсаныг сонсож. Нэхнэм гэж эмээж яарч харьж байнам. Далайн улсаас. Таныг хэлтгий суусныг Цахар мэдэж. Одоо танд мордохул танийг хэн өмгөөлөх буй яаралгүй явж мөрт танийг орж үл авах буюу улс малаа автсан хойно маний зүг оровч хэрэг буюу. Манд нийлэхүл танд амар бишүү.

29. МАНЖИЙН ХААНААС ГАЛЗУУ ШАДАРТ ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг. Галзуу шадарт илгээв. Язгуураас эдүгээ болтол над элч тасралгүй явуулав чи. Алсын явдлыг үл мэдэх ах дүүгийн үгэнд орж буруу явдлаар явах чинь яав. Дүнгэйд мордоход эс мордов түүний хойно Хятадын хааны хотод мордоход эс мордов. Түүний хойно хаврын чуулганд эс ирэв. Далинхуд мордсонд бас эс мордов энэ явдал тань зөв буюу. Тэнгэр хэрэв манийг хайрлаж Хятад Цахар хоёрыг доройтуулсан хойно. Та явах суух газар олох бэрх буй жа. Энэ үг миний бардам биш. Тэнгэр манийг хайрлаж явахад их төр ойр болжом. Одоо чи болоос урьд буруугаа мэдэж үүний хойно аливаа аян цэрэгт болзооны газар урьд хүрч ирж агтын хүчийг эвдэлгүй явж. Нутгаа хойш гаралгүй явж. Илүүд төмрөө нааш зөөж явахул урьд мууг тань нэхэж ял хийхгүй. Мөн язгуурын буруу явдлыг эс орхиж явахул манд элч явуулж яах юм. Дайсны ёсоор яв та.

30. БИЧИН ЖИЛИЙН ЦААЗ БИЧИГ

Хааны зарлигаар.

Мичин жилийн хаврын эхэн сарын арван наймнаа цааз эсгэв. Ноёд ирэх босхуулыг алахул арван айл авах. Харц хүн алахул хэдэн алагч хүнийг бүгдийг алах. Ноёныг алагч хүнийг гаргаж өгөхүл тэр алагч хүний малыг ноён авах. Гэрчээр гарахул тэр алагч хүний малыг нь босхуулын зорьсон ноён гэрчлэгч хүн хоёр хагас нь автугай. Зорьсон ноёныг эс гарахул хаан авах. Гэрчлэгч хүнд хагасыг өгөх. Ноёд хулгай далдлаж мууд орсон хойно хулгай мөн болж хойно гэрчээр гарахул тэр ноёноос хорин адуу хоёр тэмээ авах. Хулгайчийн их нэг хүнийг алах. Элч гаргах ор холбого эм хөвгүүдийг золиггүй барьж өгөх. Тэр нөхөр хулгайчийн хар биеийг гаргаж эм хөвгүүд гэр малыг нь талж авч малын эзэн гэрч хүн хоёр хагас авах. Ноёныг өөрөөсөө гаргаж өгөхүл хулгайчийн эм хөвгүүд үлсэн гэр малыг нь ноён автугай. Хар бие хүн хулгай хийхүүл тэр хошууны ноёноос ор холбого авах. Хулгай авсан малыг эврээр хүрч үснээ барихул мөн аллаганы ялд буух. Арван айлд нэг дарга тавь. Тэр арван айлаас хулгай гарахул тэр даргаас хоёр морь авах. Дарга гаргаж өгөхүл гэрчийн ёсоор автугай. Дарга эс талбихул тэр ноёноос таван морь авах. Тэр авсан морийг ялын эзэн гэрч хүн хоёр хагас автугай. Аливаа ялыг гадагш гэрчлэв гэж ноёныг баалахул тэр ноёноос найман морь нэг тэмээ авах. Баалж авсан малыг эзэнд нь хариулж өгөх. Эвэр мөр хоёрт элч, эвэрлэгч хүн хоёр ганц мал болохул ялт хүнээс автугай. Хоёр мал болохул малын эзнээс авах.

Ноёд ирэх босхуулыг алсан арван айл. Ноёд хулгай далдалж мууд орсон хойно. Хулгай гарахул тэр ноёноос хорин адуу хоёр тэмээ. Ноёд гэрчийг гадагш гэрчлэв гэж баалахул тэр ноёноос найман морь нэг тэмээ. Энэ засгаар авсан.

31. МАНЖИЙН ХААНААС НАЙМАНЫ ДАРХАН ХУН БААТАРТ ИЛГЭЭСЭН БИЧИГ

Хааны зарлиг. Цахарын хаан төрсөн төрлөө хөм алж үлсэн төрөл тань хэрс. Төрөлдөө нийлье гэж ирэжэм бишүү. Үүнийг Дархан хун баатар. Найманы ноёдта бүгдээр хайрлаж багахан цөөхөн улс мал өгөлтэй бишүү үүнд өгөв гээд та үгүйрэх буюу. Зовж ирсэн ах

дүүгээ хайрлаж авч явахул хол ойр сонсох нэр энд сайн бишүү. Жонон баатар абайг хайрлаж авч явахыг та бүгдээр эс үзвээ.

Сэцэн хааны зургадугаар он хаврын дунд сарын хоёр шинэ.

32. МАНЖИЙН ХААНААС ХАРЧИНЫ ТҮМЭД ОМБО ЦӨХҮРТ ИЛГЭЭСЭН БИЧИГ

Хааны зарлиг. Чулуунд цавчсан бичиг мэт гэх болоос. Ноднин хүүхэн улсаа. Эчиж болгож ирсүү гэсэнд жирвэсхийж хуяг морь өгөв. Эч гэсэн цагт эчилгүй. Өөрсдөөн байгаад аян . . .¹¹ болсонд эчье гэх тэр үг чинь юу бэ. Унах агтгүй болоос энэ аянд чинь бие суу. Аян буусан хойно эчиж хүүхнээ болгоож ир.

33. МАНЖИЙН ХААНААС ХОРЧИНЫ ЦОСХИД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг. Цосхид илгээв. Аян чуулган хоёрт үл ирнэм та. Хазгай буруу нутаглаж явж улс малаа автаад над хэлэх хэрэг буюу. Болов юуг таны мууг санам. Чуулах болзооны газар ир. Тэнд хэлэлцэе.

34. БИЧИН ЖИЛИЙН ӨВЛИЙН ЦААЗ

Хааны зарлигаар. Жаргалан ноён. Сахалян ноён. Мичин жилийн өвлийн эхэн сарын таван шинэд Шарилжтайд эчиж нутгийн жасааг зааж өгөөд. Цааз эсгэв. Монцогоос Бага сард хүртэл Сүн Дүүрэн. Бага сараас Хоточид хүртэл Баарин, Хоточоос Хуваданд хүртэл Аохан Найман. Хувадангаас Бяруут ханханд хүртэл Дөрвөн хүүхэд Далай. Бяруут ханханаас Тарганд хүртэл Жарууд. Жасааны нутгаас биш хүний нутагт ноёд орохул арван адуу. Харц хүн орохул даргаас нэг морь авах. Шар мөрнийг гарахул дайсны ёсоор хийх. Ирэх босхуулыг ноёд алахул. Арван айл авах. Харц хүн алахул хэдэн алагч хүнийг бүгдийг алах. Эм хүүхэд гэр малыг нь зорьсон ноён автугай. Ноёд алагч хүнийг гаргаж өгөхүл түүний эм хүүхэд гэр малыг гаргагч ноён автугай. Зорьсон ноёнд ор холбого өгтүгэй. Гэрчээр гарахул тэр алагч хүний эм хүүхэд гэр малыг босхуулын зорьсон ноён гэрчлэгч хүн хоёр автугай. Ноёд хулгай хийхүүл зуун адуу арван тэмээ авах. Харц хүн хулгай хийхүүл хэдэн хулгайчийг бүгдийг алах. Эм хүүхэд гэр малыг солиггүй барьж өгөх. Малын эзэн гэрчлэгч хүн хагас автугай. Хулгайчийн даргаас хоёр морь авах. Хулгайчийн ноён нь өөрсдөө гаргаж өгөхүл ор холбого элч гарах өгтүгэй. Эм хүүхэд үлсэн гэр малыг нь ноён нь автугай. Хар бие хүн хулгай хийхүүл тэр хошууны ноёноос ор холбого элч гарах авах. Хулгай авсан малыг эврээр хүрч үснээ барихул мөн аллаганы ялд багтах. Хулгайчийг дарга гаргаж өгөхүл мөн гэрчийн ёсоор автугай. Ноёд хулгайчийг далдалж мууд орж хойно хулгай мөн болж гэрчээр гарахул тэр ноёноос хорин адуу хоёр тэмээ авах. Айлын даргыг алах. Арван айлд нэг дарга тавь. Дарга эс талбихул тэр ноёноос таван морь авах. Аливаа ялыг гадагш гэрчлэв гэж ноёныг баалахул баалагч ноёноос арван адуу нэг тэмээ авах. Баалж авсан малыг эзэнд нь хариулж өгөх. Эвэр мөр хоёрт элч, эвэрлэгч хүн хулгайчаас автугай. Хулгай авсан малыг барихул баригч хүн нэг сонгодог автугай. Хулгайчийг хоёр ноён зохицож эс алахул хориод адуу хошоод тэмээ авах. Нэнгжихүл эс өгөхүл аллаганы ялд багтав, нутагт мөн өдөр мөр орохул шахах болов. Жуулчин хүнийг улаачлах болов. Эс улаачилахул шүдлэн үхэр автугай. Аливаа зүгээс дайсан ирж захын улсыг довтолбол аливаа хошуу гэр малаа дотогш болгоод цэргээ бүгд авч довтолсон зүгт яарч цугла. Эс цугласан ноёдыг улсаас гаргах. Цугласан хойно нэхэх халахыг бүгдээр зөвлөж мэд. Хорин саадагт хүн босхуул өөрийн хошуу нэхтүгэй. Хорин саадагт хүн эс дээш босхуул хоршсон босхуулын тэнгээр нэхтүгэй. Эс нэхэхүл хорин адуу хоёр тэмээ авах. Бүхэл хошуу босхуул аливаа хошуу ялгаагүй цэргийн ёсоор мордож нэхэх. Эс нэхсэн ноёдыг мөн улсаас гаргах болов. Аливаа хүн босхуул нэхэхүл эхлэгч хүнийг алахул түүний олзыг нэхсэн хүн автугай. Эхэлсэн хүнийг гаргахул олзыг үл өгөх. Аливаа ялыг авах хүн ялын эзэн тусгаар эчиж хэлэлцэж ав. Хэрвээ эс өгөхүл өөрийн хошууны засгийн ноёдоос элч авч ялт хүнд хүрч улаа унаж шүүс идэж хэлэлц. Ил гарсан аллагын ял гарахул хаанаас элч авах болов. Ноёд

¹¹ Энд байсан нэг үг гаргагдахгүй болжээ.

босхуулыг алсан арван айлын морины жолоо мэдтүгэй гэж ирсэн босхуул. Ноёд хулгай хийхүүл зуун адуу арван тэмээ. Ноёд хулгайг дарж мууд орж хойно гарахул хорин адуу хоёр тэмээ. Арван айлд дарга эс тавьсан ноёноос таван морь. Босхуулыг эс нэхсэн хорин адуу хоёр тэмээ. Гадагш гэрчилсэн хүнийг баалсан ноёноос арван адуу нэг тэмээ. Хулгайчийн хоёр ноён зохицож эс алахул хориод адуу хошоод тэмээ. Энэ засгаар авсныг хаан авах болов. Сэцэн хааны зургадугаар он өвлийн эхэн сарын таван шинэд.

35. АРЫН ХАЛХААС МАНЖИЙН ХААНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Ум Сувасди сидам сайн амгалан болтугай. Маха Самади Сэцэн хаан. Түшээт хаан Сэцэн жонон эхлэн их бага ноён. Усны жаран гурван омогтны эзэн болсон Сэцэн хаанд бичиг өргөн барив. Бичиг барихын учир. Хан хүнд хас их төр хамагт сонсдох сайн алдар нэр хэрэгтэйн тулд. Хамгаас төр шажныг мандуулах нэрийг эрэлтэй. Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидний өөргүйн тулд хас их төрийг хадгалж суунам бид. Энэ их төрийг санахул нь нааш цааш элч юугаа тасралгүй мэнд асуулцаж явъя. Ийн хийж явахул эрдэнэт хүний төрөл олж, эрх хүчит хан болон төрсний гавъяа бидний тэр ажааму гэж айлтганам. Элчийн нэр Гарма Чойбал Сэцэн бандида бий.

36. ХАЛХЫН МАХА САМАДИ СЭЦЭН ХААНЫ ЗАРЛИГ

Ум Сувасди чүдам.

Олноо Өргөгдсөн Маха Самади

Сэцэн хааны зарлиг.

Тайху эрх хүүхэн. Зэлмэ дархан ноён тэргүүлэн, хэдэн зайсангуудад бичиг өгөв. Урьд чи болоос, Хун ноёныг барьж өгчээ, үгээн хүндлэлцэж, үйлээ бүтээлцэж явлаа. Хойно чи болоос. Гэмгүй төрийн самуунд нааш цааш эс явалцлаа. Бид тустан үг гэмгүй өшөө хясаа үгүй билээ. Хаан дээд төрөлдөө өөд болж та бүгдийг айсуу гэхийг сонсож, амурай харигулаар болгож байлаа. Ханд төрөл билээ. Харцаст эзэн билээ, саадгүй ирэлтэй байнам. Цамц дээл гэхэд Тайху мань хатанд охин дүү билээ. Бишэнд эчин гэхүл, төрөөр ч төрснөөр ч шадар минь билээ. Бас бас дотроо мэд мэд. Элчийн минь нэр Гарм Цэнбуй бандида, Бонсог хиа хоёр буй. Бэлэг нэг морь буй. Ман га лам.

37. МАНЖИЙН ХААНААС ГОЛТ СЭЦЭНД ЦОЛ ОЛГОСОН БИЧИГ

Хааны зарлиг Голт Сэцэн Цахарын хааны Наннан тайхуг ёсоор мэнд авч ирсний тулд өршөөж Зоригт Дархан ноён цол дуудаад алтан тамгат бичиг соёрхов. Аяны тэргүүнээ авын дунд явтугай. Хоногт шүүс идэх болов. Үрийн үрд хүртэл улаа шүүс өгөхгүй. Язгуурын нэрийг эр хүн нэрлэвээс эмээлт морь. Эхнэр хүн нэрлэвээс ууж дээл авах. Нэгэн моринд сийлсэн эмээл тохож хуяг татсаар өгөв. Сэцэн хааны өсдүгээр он намрын тэргүүн сарын хорин дөрвөнөө.

38. АР ХАЛХЫН МАХА САМАДИ СЭЦЭН ХААНААС МАНЖИЙН СЭЦЭН ХААНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Ум Савасди Сидам. Суут Богд Чингис хааны алтан ураг Маха Самади Сэцэн хаан эхлэн. Хотлыг ялгуусан Сэцэн хаанд бичиг өргөн барив. Бичиг барихын учир. Бид энд мэнд аму. Тэнд Сэцэн хаан амгалан уу. Эвдэршгүй төрийг эвдэв Хутагт хаан. Энхжүүлэх төрийг тэнд Сэцэн хаан мэд. Хас их төр хамгаа алдарших сайн нэр ертөнцийн чимэг бүхүйн тэлд энд тэнд төр шажныг наран мэт мандуулхул төрсний гавъяа гэлэгт хүрэх сайн нэр тэр ажааму. Энэ үгийг гэгээндээ айлдаж зөв гэхүл нааш цааш тасралгүй мэнд юугаан асуулцаж төрийн хадаас шашны наран болж эе нэр хоёрыг эвдрэлгүй сахилдая. Хааны элч Үйзэн лам бичээч Дархан Убаши Дархан тавнан. Довдой бинт хиа дөрвөн хүн бий. Үзэмчний Сэцэн жонон. Сөнөдийн Баатар жонон. Хуучидын Илдэн Түшээт. Авгын Засагт жонон. Ер их бага ноёдын элчид олон бий.

39. МАНЖИЙН СЭЦЭН ХААНААС АР ХАЛХЫН МАХА САМАДИ СЭЦЭН ХААНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг. Халхын Маха Самади Сэцэн хаанд илгээв. Энхжих их төрийн учрыг намайг мэд гэж байнам. Тэр үг тань зөв. Би аливаа улсад, гэм шалтгаангүй авах идэхийн тулд дайлсангүй бид. Эртний өшөөт Хятад улсыг дайлж явахуйд Цахарын хаан.Хятадын эд таваарт орж. Цэрэг нэмсний тулд, Цахарыг дайлсны шалтгаан бидний тэр бөлгөө. Түүгээр тэнгэр газар Цахарын хааныг буруушааж. Цахар улсыг над дор соёрхов. Эдүгээ Хятад дор агтаа худалдаж эд таваар авч явах таны. Хятад улсад хүч нэмсэн биш буюу. Тэр буруу явсныг тань нэхэж санах биш бид. Төр цааз нэгдэх байхын учрыг таны үгийг сонсож мэдье.

40. МАНЖИЙН ХААНААС СЭЦЭН ЖОНОНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг.

Сэцэн жононд илгээв. Илгээсэн бичгийг чинь. Би үзэв. Халхад түшсэн хүнийг газрын холоос ямрыг мэдэж хэлэм бид. Аливаа явдлын учир та мэднэм жэ.

41. МАНЖИЙН СЭЦЭН ХААНААС ЭРДЭНЭ НОМЧИД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг.

Эрдэнэ Номчид илгээв. Илгээсэн бичгийг чинь. Би үзэв. Халхад түшсэн хүнийг газрын холоос ямрыг мэдэж хэлэм бид. Аливаа явдлын учрыг та мэднэм жэ.

42. МАНЖИЙН ХААНААС ЗАСАГТ ЖОНОНД ИЛГЭЭСЭН БИЧИГ

Сэцэн хааны зарлиг бичиг.

Засагт жононд илгээв. Илгээсэн бичгийг чинь үзэв. Цааз нэгтгэе гэж хэлэлцэж явалцсан бидний үнэн. Та үгээ эвдэж Халхад нийлэв. Бид эвдсэнгүй. Эдүгээ, би юу хэлнэм.

43. МАНЖИЙН ХААНААС ТОЛБОТОД ЦОЛ ОЛГОСОН БИЧИГ

Хааны зарлиг. Толботыг Халхад урваж эс суув гэж өршөөж Дархан цол өгөөд. Алтан тамгат бичиг соёрхов.

БАРИМТЫН ТАЙЛБАР

24. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 5-р оны 11-р сарын 28-наа (1632.1.19) Манжийн Тэнгэрийн Сэцэн хаанаас Түшээт хаанд илгээсэн бичиг болно.

25. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 5- оны 12-р сарын 11-нээ (1632.1.31) Таншайг Талингуу голын байлдаанд сайн ялав хэмээн дархан цол олгосон бичиг болно.

26. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 5-р оны 12-р сарын 16-наа Манжийн Сэцэн хаанаас Монголын Сэцэн дүүрэн, Банди Үйзэн, Далай зайсан, Шиян мэргэн, Бамбу цөөхүр, Тун дайчинд Баяраар, Далай цөөхүр, Дар эх, Хайсан баатар, Дөрвөн хүүхдэд Хөвхдүйгээр, Баарин, Есүд, Хар цэрэг, Харчин, Түмдийн ноёдод тавнангуудад Сүдригээр, Аохан, Найман, Жарууд, Баруун гар, Зүүн гарт Очдоор тус тус илгээсэн бичиг болно.

← Сүн дүүрэн – Онигууд аймгийн Отчигин ноёны ахмад хөвгүүн Баяндай хонхор ноёноос эхлэн Онигууд гэх аймгийн нэр үүсэв. Баяндай хонхор ноёноос хоёр үе уламжлаад Дөлөнд хүрч Дүүрэн хан хэмээн өргөвэй. Түүний ахмад хөвгүүн Сүн дүүрэн.

↑ Банди үйзэн – Дүүрэн ханы дөрөвдүгээр хөвгүүн.

→ Далай зайсан – Дөлөний тавдугаар хөвгүүн Далай номч бололтой. Бас Тархай номч хэмээмүй.

↓ Шиян мэргэн – Бас Аян мэргэн хэмээмүй. Сүн дүүрэн ханы зургадугаар хөвгүүн.

° Бамбу цөөхүр – Дүүрэн ханы долдугаар хөвгүүн. Бас Бумба чөтгөр буюу Бумба цоохор гэдэг.

± Түн дайчин – Дүүрэн ханы гуравдугаар хөвгүүн.

" Хайсан баатар – Багун ноён П→ Бүни мэргэн П← Хайсан.

≥ Дөрвөн хүүхэд - Чингисийн дүү Хавт Хасарын арван тавдугаар үеийн ач Ноёндой, түүнд дөрвөн хөвгүүнтэй: ахмад нь Сэнгэ мэргэн хошууч, хоёрдугаар нь Сономдар тайж, гуравдугаар нь Омбу бөхү тайж, дөрөвдүгээр нь Эрчим мэргэн тайж. Дөрвүүл тус тусдаа нутаглаж байсаар хойно даруй тэд нарын нэрээр аймгийн нэр болговой. Омбугаар захируулав.

× Хар цэрэг – Галданы "Эрдэний эрхи"-д энэ аймаг болбоос Тайзу хааны дүү Отчигины хоёрдугаар хөвгүүн Бадарыг Цэцэн ноёноос эхлэн нэрийдэв хэмээв. Ман Мугийн "Монголын хошуу нутгийн тэмдэглэл"-д Отчигины хойчис Мөнгө цагаан ноён хоёр хөвгүүнтэй буюу. Ахмад нь Баяндай хонхор ноён. Аймгийн нэрээ Онигууд гэв. Хоёрдугаар хөвгүүн нь Бади сэцэн ноён. Аймгийн нэрээ Хар цэрэг гэв. Бүр Ар Монгол хэмээмүй. Хожим Хар цэрэг аймаг Онигуудтай нийлжээ. Ар хэмээх нэрээ орхив гэжээ.

27. Энэ бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 4-р сарын 6-наа (1632.5.24) Манжийн их цэрэг Хар хошуунд буудаллаж, Манжийн хаанаас нэр үхэр, хоёр хонь алуулж, өөрийн хошууны шадар цэрэг, тугийн эзэн, хошууны эзэн, монгол тайж нар жич Талинху голын шинээр бууж өгсөн хятад ноёдыг цуглуулан хуримлахад Харчин Монголын ноёдод буулгасан зарлиг бичиг болно.

28. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 1-р сарын 3-наа (1632.2.22) Манжийн хаанаас Арын Урад улсын хаан тайху Хүмү хун баатар, Цогт бөх ноён, Тоба эрх тайж, Хавунайж ноён, Түмэн дархан тайж, Мож төрөл ноён, Түй хатан баатар нарт Арын хааны нэгэн элчин, Тайхугийн нэгэн элчин, Тобагийн нэгэн элчин гурваар илгээсэн бичиг болно.

29. Энэ бичиг бол Тэнгэрийн Сэцэний 6-р оны 6-р сарын 24-нөө (1632.8.9) элчин Убашаар Галзуу шадарт илгээсэн бичиг болно.

← Гэлзуу шадар – Болхуй П Түмэй заяагч П← Хүй мөнх тас хар П Додьдар зорхал П← Илжиг зоригт П↑ Шадар галзуу ("Алтан хүрдэн мянган хигээст").

30. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 1-р сарын 18-наа (1632.3.8) Манжийн хаан Хунтайжийн зарлигаар эсгэсэн цааз бичиг болно.

31. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 65-р оны 2-р сарын 2-нд (1632.3.10) Манжийн хаан Хунтайжаас Монголын Найманы Харам тайжаар Дархан хун баатарт илгээсэн бичиг болно.

32. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 3-р сарын 27-ноо (1632.5.15) Манжийн хаанаас Харчины Түмэд Омбу цөөхүрт илгээсэн бичиг болно.

33. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 3-р сарын 29-нөө (1632.5.17) Манжийн хаанаас Хорчины Цосхид илгээсэн бичиг болно.

34. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 6-р оны 10-р сарын 5-наа (1632.11.16) Манжийн хааны зарлигаар Жаргалан ноён, Сахалян ноён Монгол улсад цугларан очиж, шашныг тогтворжуулах тухай тогтоосон цааз бичиг болно.

35. Энэ бичиг бол Манжийн Тэнгэрийн Сэцэний 9-р оны 5-р сарын 27-ноо (1635.7.11) Арын Халхаас Цахарын Соном хиа тайжид Манж улсын Сэцэн хааны хүнтэй

дайралдваас өгөөсэй гэсэн бичгийг Манж хаан гардан авч дансанд тэмдэглэсэн бичиг болно.

36. Энэ бичгийг Арын Халхын Маха Самади Сэцэн хаанаас Цахар хааны хатан Сутай тайху, түүний хөвгүүн Хонгор жич бусад ноёдод буулгасан зарлиг болно. Тус бичиг Манжийн Тэнгэрийн Сэцэний 9-р оны 5-р сарын 27-ноо (1635.7.11) “Арын Халхаасё Манжийн хаанд илгээсэн бичиг”-тэй хамт Манжийн хааны гарт орж дансанд тэмдэглэгджээ.

37. Энэ бичгийг Манжийн Тэнгэрийн Сэцэний 9-р оны 7-р сарын 20-ноо (1635.9.1) дансанд тэмдэглэжээ. Гэтэл монголоор Сэцэн хааны 9-р оны намрын тэргүүн сарын 24 гэж тэмдэглэсэн байна.

38. Энэ бичиг Манжийн Тэнгэрийн Сэцэний 9-р оны 12-р сарын 7-ноо (1636.1.14) дансанд тэмдэглэгджээ.

39. Энэ бичиг бол Дээд Эрдэмтийн анхдугаар оны 2-р сарын 2-ноо (1636.3.8) Манжийн хаанаас Үй зайсан, Барай санжин, Бэбухайгаар Ар Халхын Маха Самади хаанд илгээсэн бичиг болно.

40. Энэ бичиг бол Дээд Эрдэмтийн анхдугаар оны 2-р сарын 2-ноо (1636.3.8) Манжийн хаанаас Сэцэн жононд илгээсэн бичиг болно.

41. Энэ бичиг бол Дээд Эрдэмтийн анхдугаар оны 2-р сарын 2-ноо (1636.3.8) Манжийн хаанаас Эрдэнэ номчид илгээсэн бичиг болно.

42. Энэ бичиг бол Дээд Эрдэмтийн анхдугаар оны 2-р сарын 2-ноо (1636.3.8) Манжийн хаанаас Засагт жононд илгээсэн бичиг болно.

43. Энэ бичиг бол Дээд Эрдэмтийн анхдугаар оны 2-р сарын 2-ноо (1636.3.8) Манжийн хаанаас Толботод цол олгосон бичиг болно.

**“The documents related to the Mongol-Manchu relation
of the first half of XVII century.”**

Resume

*By G. Dashnyam (Ph.D.)
Ts. Turbat, D. Enkhtsetseg*

The surveys related to the history of Mongol-Manchu relations of the XVII century are mainly in Mongol, Manchu and Chinese.

There are many documents dated back to the 1620's to the initial stage of Mongol-Manchu relation development. The 43 Mongol scripts related to the XVII century is publishing now. These publishing documents give new and valuable information and correct some misinterpretations in Mongolian historiography regarded to the initial stage of relations between Outer Khalkha princes, nobilities and Manchu, to the Manchu conquest of Inner Mongolia, to the Manchu evaluation of heirless Great Mongol State after death of Ligden Khaan in Shar steppe, to the doctrines and policies first regard to Manchu.